

МОНГОЛЫН СЭТГҮҮЛИЙН ДИЗАЙНЫ ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ

М. Наранмандах*

* СУИС-ийн Радио телевизийн сургуулийн сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, магистр,
докторант

Түлхүүр үг: сэтгүүлийн дизайны үндэс, сэтгүүлийн дизайны тулгуур элементүүд, шрифт, хавтас, багана, гэрэл зураг, өнгөний зохицлын өөрчлөлт, шинэчлэл

Дизайныг хамгийн энгийнээр тайлбарлавал зохицол буюу нэгэн бүхэл дэх мэдээллийг агуулагч бүх элементийн нэгдэл юм. "Сонины дизайны гол зорилго нь уншигчдын сэтгэл зүйд нөлөөлөхөд оршино. Сонин шрифт, гэрэл зураг, агаар, өнгөний цохилт, хэв загвараараа уншигчдад нөлөөлнө"¹. Сэтгүүлд ч гэсэн сонины нэгэн адилаар дизайн нь уншигчдад нөлөөлөх маш чухал үүрэгтэй байдаг. Сэтгүүл тус бүр өөрийн гэсэн өнгө төрх, онцлог шинж, зорилт, зорилго бүхий дизайнтай байдаг. Уншигчид ихэвчлэн өөрийн сонирхсон зүйлтэйгээ холбоотой сэтгүүл худалдан авдаг. Жишээ нь машин, спорт, загварын тухай сэтгүүл гэх мэт. Ерөнхийдөө сэтгүүлийн нийтлэлийн бодлого, чиглэлээс хамаарч дизайн тодорхойлогддог. Монголын сэтгүүлийн дизайны өөрчлөлт шинэчлэлийн асуудлыг хөндөхийн тулд орчин цагийн

монгол бичиг кирилл үсгээр хэвлэгдэж байсан 1940-2010 хүртэлх сэтгүүлүүдийг судалсан болно.

"1940 онд манай улсад таван сонин, долоон сэтгүүл нийтдээ 90 орчим мянган хувь хэвлэгдэж 10 хүнд нэг сонин, сэтгүүл ноогдож байсан"² байна. Дөчөөд оны сэтгүүлүүдийн дундаас "Багш нарт тусламж" сэтгүүлийг сонгон авч судаллаа. Тус сэтгүүл нь 1930 оноос хойш нэрээ хэд хэдэн удаа өөрчилсөн бөгөөд 1980-аад онд сар тутам нэг удаа 17 мянга гаруй хувиар хэвлэгдэж байв³. Дөчөөд оны сэтгүүлүүдийн дотроос тогтмол, тасралтгүй хэвлэгдэж байсан учраас тус хэвлэлийг сонгон авлаа. Дөчөөд оны дунд үеэс тавиад оны мөн үе бол сэтгүүлийн нэр төрөл олширч, чанар сайжирч, бичлэгийн төрөл зүйл баяжсан жилүүд байсан хэдий ч дизайны хувьд өөрчлөлт, шинэчлэл ороогүй үе гэж болохоор байна. Учир нь тус сэтгүүлийн дугаар бүр нэгэн ижил дизайнтай хэвлэгдэж байжээ. Тухайн үед уг сэтгүүл нь 156 хуудсаар гардаг байсан бөгөөд зөвхөн хар, цагаан өнгөөр хэвлэгддэг байсв. Энэ сэтгүүлийн эхэн үеийн дизайны сонирхол татах хэсэг нь монгол

бичгээр мэдээлэл нь гардаг байсан ажээ. "1942 онд орос кирилл үсгийг монгол бичиг болгон хэрэглэсэн нь тавиад оны үеэс ихэд тархан, орчин цагийн монгол бичиг үсэг болсон ба үүнээ дагасан үсгийн дүрэм буй болж сүүлийн жаран жилд хэрэглэн явцын дунд улам сайжирсаар манай үндэсний бичиг үсэг болсон юм"⁴.

1965 онд төв, орон нутгийн 36 сонин, 27 сэтгүүл нэг удаагийн гаралтаар сая гаруй хувь хэвлэгдэж манай орны нэг хүнд нэг сонин, сэтгүүл оногдох болжээ⁵. Жаран оны дунд үе гэхэд сэтгүүлийн тоо өмнөх үеийнхээс хориор нэмэгдсэн байна. Энэ үеийн сэтгүүлүүдээс хамгийн онцлог, өвөрмөц, дизайны хувьд анхаарал татсан нь "Зөвлөлт Холбоот Улс" сэтгүүл юм. Монгол хэл дээр орчуулан гаргадаг байсан тус хэвлэл нь манай улсад сэтгүүлийн жинхэнэ дүр төрхийг бий болгосон гэж хэлж болно. Тус сэтгүүл нь тухайн үеийн монгол сэтгүүлүүдээс эрс ялгарч байв. Өөрөөр хэлбэл, орчин үеийн сэтгүүлд тавигдах ерөнхий зарчмуудыг хангаж байсан нь анхаарал татаж байна. Мөн "Зөвлөлт Холбоот Улс" нь туслах бичлэгийн зүйл болох онигоо, сонин хачин гэх мэт тогтмол булантай байсан нь сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйлд ч шинэ чиг хандлагыг бий болгожээ.

1987 оны байдлаар хорь хоног, сар, хоёр сар, улирал тутам гардаг 36 сэтгүүл хэвлэгдэж байсан бөгөөд тэдгээрийн жилийн нийт хувь 6.6 сая ширхэгт хүрч байлаа⁶. 1980-2000 оны үеийн сэтгүүлүүдээс жишээ болгон "Цог" сэтгүүлийг сонгон авсан юм. Утга, уран зохиолын "Цог" сэтгүүл нь 1944 оны 4-р сараас гарч эхэлсэн бөгөөд наяд онд хоёр сар тутамд 30 мянган

хувиар гарч байв⁷. "Цог" нь сэтгүүл гэхээсээ илүү уран зохиолын ном шиг хэлбэр, хэмжээтэйгээр хэвлэгдэн гардаг байсан байна.

2000 оноос хойшх сэтгүүлүүдийн төлөөлөл болгон "Гялбаа", "Гоодаль"-ийг сонгон авлаа. "Гялбаа" сэтгүүл 2003 оноос хойш өнөөг хүртэл үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, өөрийн гэсэн өнгө төрхийг бий болгож, уншигчдын дуртай сэтгүүл болж чаджээ. Тус хэвлэл уншигчдын тоогоороо сэтгүүлийн зах зээлийг тэргүүлж байгаа нь Монголын хэвлэлийн хүрээлэнгээс жил бүр гаргадаг "Хэвлэл мэдээлэл" судалгаанаас тодорхой харагддаг. "Гоодаль" сэтгүүл нь нийтлэлийн бодлого, дизайнаараа энэ үеийн бусад сэтгүүлээс эрс ялгардаг учраас энд давхардуулан сонгон судаллаа. Эдгээр нь орчин үеийн Монголын сэтгүүлүүдийн өнгө төрхийг илэрхийлж чадахуйц, чамин тансаг өвөрмөц дизайнтай сэтгүүл болно. Дизайных нь талаас шрифт, хавтас, гэрэл зураг, хуудасны тоо, багана, нийтлэлийн бодлого, өнгөний зохицол зэргээр нь харьцуулан судалж үзлээ.

Ө нөөдөр мянга гаруй төрлийн шрифт байгаа нь шрифт бол үргэлж шинээр бий болж, хувьсч өөрчлөгдөж байдгийг харуулж байна. Шрифтийн хувьсал өөрчлөлт нь сэтгүүлийн дизайнд онцгой нөлөөтэй. Тухайлбал, 1940 оноос 2010 он хүртэлх Монголын сэтгүүлүүдийг шрифтийг судлахад 2000 оноос л эхэлж сэтгүүлүүд олон янзын шрифтийг ашиглаж ирсэн байна. Өөрөөр хэлбэл, 2000 оноос өмнөх сэтгүүлүүдийн шрифт нь ном хэвлэлийн адил нэг ижил байсан юм.

Хавтасны хувьд анхны сэтгүүлүүд нимгэн хавтастай, хавтасны чимэглэл

нэг өнгөтэй байснаа 1960 оноос хойш цаас нь зузаарч, гэрэл зурагтай болж эхэлжээ. “Сэтгүүлийн хавтас нь уншигчтай харилцахуйн хувьд хамгийн эхний төдийгүй шийдвэрлэгч нөлөө бүхий орон зай билээ. Үүнд хавтасны зураг, дүрээр сэтгүүлийн агуулга, уншигчийн хүрээ, имиж, үнэ цэн төдийгүй, шинэ, хуучин дугаар, өвөрмөц онцгой эсэх, басхүү дизайны мөн чанарыг хүртэл илэрхийлэх нь бий. Нөгөө талаар нэр хүнд, амжилт, од болох гэгч сэтгүүлийн хавтасаар төлөвшдөг гэлцдэг”⁸. Энэ

ойлголт манай сэтгүүлүүдэд 1990 оноос хойш орж ирсэн нь судалгаанаас харагдаж байна. Өнөөдөр нэр хүндтэй сэтгүүлийн нүүрэнд гэрэл зургаа гаргах хүсэл сонирхол, эрэлт урлаг соёл, спортын алдартнуудаас гадна улс төр, бизнесийн хүрээнийхэнд ч хэдийн бий болжээ. Сэтгүүлийн дизайны хамгийн шилдэг уламжлал нь олон тооны фото зурагтай, гялгар цаасан дээр хэвлэгдэх юм. Дараах хүснэгтээс Монголын сэтгүүлийн дизайны өөрчлөлт, шинэчлэлийг харж болно.

Монголын сэтгүүлийн дизайны онцлог 1940-2000 он

Хүснэгт №1

№	Ерөнхий элемент	1940-1960 он “Багш нарт тусламж сэтгүүл”	1960-1980 он “Зөвлөлт холбоот улс” сэтгүүл	1980-2000 он “Цог” сэтгүүл	2000 оноос хойш “Гялбаа” сэтгүүл	2000 оноос хойш “Гоодаль” сэтгүүл
1	Нийтлэлийн чиглэл	Боловсрол	Чөлөөт	Утга зохиол	Чөлөөт	Чөлөөт
2	Өнгөний зохицол	Хар цагаан	Хар цагаан	Хар цагаан	Өнгөт	Өнгөт
3	Шриффт	Монгол бичгээр	Нэгэн ижил	Нэгэн ижил	Олон янз, өвөрмөц	Олон янз, өвөрмөц
4	Хуудасны тоо	156	55	171	105	200
5	Багана	Байхгүй	Гурван баганад хуваагддаг	Баганад хуваагдаагүй	Гурав ба түүнээс дээш	Гурав ба түүнээс дээш
6	Гэрэл зураг	Байхгүй	Өнгөт гэрэл зураг	Хар гэрэл зураг	Өнгөт, зохиомжтой	Хар цагаан, өнгөт зураг хосолсон, зохиомжтой
7	Хавтас	Нимгэн цаасан	Өнгөт, нимгэн, гэрэл зурагтай	Өнгөт, нимгэн, гэрэл зурагтай	Өнгөт, гялгар, мэргэжлийн гэрэл зурагтай	Өнгөт, гялгар, мэргэжлийн гэрэл зурагтай

Үүнээс харахад манай улсад сэтгүүл нь анх монгол бичгээр, хар цагаан өнгөтэй, хар-цагаан гэрэл зураг бүхий, элдэв чимэглэлгүй гарч байснаа “Зөвлөлт Холбоот Улс” сэтгүүл орчуулагдан хэвлэгдэх болсноор сэтгүүлийн цаасны

чанарт өөрчлөлт гарч, нимгэн бор цаасан дээр биш зузаан шохойтой цаасан дээр, гэрэл зураг өнгөтөөр гарч эхэлжээ. Энэ үеийн сэтгүүлүүдийн онцлог нь кирилл үсгээр, нүүрний болон бусад хуудасны мэдээлэл болон

гэрэл зураг нь өнгөт болж, уншигчдын анхаарлыг татах болсон байна. Энэ үеийн сэтгүүлийн гэрэл зургууд ихэвчлэн хар-цагаан, тод бус байснаа аажмаар сайжирч, өнгөт гэрэл зургийг чанартай хэвлэх болжээ. "Зохиомж сайтай гэрэл зураг нь тод сайхан гарсан нөхцөлд уншигчдын цагийг хэмнэж, үйл явдлын тухай үнэн зөв мэдээлэл өгч мөн тухайн сонинд нийтлэх материалд чухал байр эзлэхээс гадна сонины

дизайны өнгө үзэмжийг сайжруулж үр дүнтэй байлгаж чаддаг"⁹. Дизайны хувьд нэгэн хэвийн, бие-нээсээ ялгарах онцлоггүй байсан бөгөөд 1990 он гарсаар сэтгүүлийн хэв маяг, өнгө үзэмж, дизайн, зохиомж, агуулгын багтаамж эрс өөрчлөгдөж өнөө-

гийн өнгө төрхөө олж эхэлсэн юм. 1990 оны 1-р сарын 1-ний байдлаар 124 сэтгүүл улсын бүртгэлд бүртгүүлсэн байв¹⁰. Энэ нь өмнөх 1987 оныхтой харьцуулахад сэтгүүлийн тоо 4,5 дахин буюу эрс нэмэгдэж, зах зээлийн өрсөлдөөн бий болсон нь сэтгүүлийн дизайнд онцгой нөлөө үзүүлсэн байна. Харин 2010 онд 102 сэтгүүл бүртгэлтэй байсан нь сүүлийн арваад жилийн хамгийн өндөр үзүүлэлт болжээ. Энэ мэтчилэн сэтгүүлийн тоо нэмэгдэхийн хэрээр чанар, дизайн сайжирч, өөрчлөгдсөөр өнөөдрийг хүрчээ.

Дээрх судалгаанаас харахад сэтгүүлийн дизайны хөгжлийн ерөнхий чиг

хандлагыг харж болох юм. "Сонин сэтгүүлийн редакциуд мэдээллийн үйлдвэрлэлээ тасралтгүй явуулахын тулд өөрийн боломж бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаж, аж ахуй, санхүүгийн хувьд найдвартай байхын тулд шинэ техник, технологиор өөрийн үйл ажиллагааг шинэчилж, зөв менежментээр ажиллах шаардлагатай боллоо"¹¹. Энэ үүднээс 1990 оноос нийгмийн тогтолцооны өөрчлөлтийг да-

гаж, хэвлэлийн дизайн, технологид нэлээдгүй өөрчлөлт гарсан нь сэтгүүлд бодит нөлөөлөл, өөрчлөлтийг авчирчээ. "Ерөөс сэтгүүлийн дизайны шинэчлэлтийг хэвлэлийн техник, технологийн хөгжил, түүний боломж нөхцөл, чадавхтай холбон үзэх хэ-

рэгтэй. Гэрэл зураг, график илэрхийллийн чанар чансаа, илэрхийллийн янз бүрийн хэлбэр, хувилбар гээд техник, технологиос шууд шалтгаалах зүйл их бий"¹². Гэвч зөвхөн хэвлэлийн техник технологи төдийгүй, бусад техник, технологи тэр дундаа дижитал технологийн хөгжил сэтгүүлийн дизайнд өөрчлөлт авчирч байна. Үүний нэг тод жишээ бол ухаалаг гар утасны "Дээжис" дижитал сэтгүүл бий болсон явдал юм. Сар тутмын тус дижитал сэтгүүлийг дурын уншигч гар утаснаасаа үнэгүй татаж үзэх боломжтой. Энэхүү сэтгүүл нь тав дахь дугаараа гаргах үедээ 15.000 хэрэглэгчтэй

«
Манай улсад сэтгүүл нь анх монгол бичгээр, хар цагаан өнгөтэй, хар-цагаан гэрэл зураг бүхий, элдэв чимэглэлгүй гарч байснаа "Зөвлөлт Холбоот Улс" сэтгүүл орчуулагдан хэвлэгдэх болсноор сэтгүүлийн цаасны чанарт өөрчлөлт гарч, нимгэн бор цаасан дээр биш зузаан шохойтой цаасан дээр, гэрэл зураг өнгөтөөр гарч эхэлжээ.

»

байсан бол 2013 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 50.000 хэрэглэгч утсандаа татаж авчээ. Мөн сэтгүүлийн дизайнд өөрчлөлт авчирч буй шинэ үзэгдэл нь 7-10 хоногийн сонин нэрээ өөрчлөх, эсвэл нэр болон нийтлэлийн бодлогоо хэвээр нь хадгалан сэтгүүл болж байна. Тухайлбал, "Хонгорзул", "Соронз" зэрэг сэтгүүлийг нэрлэж болно.

Орчин үеийн сэтгүүлийн дизайн нь өөрийн гэсэн өвөрмөц шинжийг хадгалан шинэчлэгдсээр байна. Тухайлбал, шрифтийн хувьд олон сонголттой болж хүний анхаарлыг татах чадвар нь дээшилжээ.

Түүнчлэн гэрэл зураг нь өнгөт, хавтас нь гялгар, зузаан, хавтсан дээрээ өнгөт гэрэл зурагтай болж өмнөх жилүүдээ бодоход чанар, дизайн хийцийн хувьд аажим, аажмаар сайжирсаар ирсэн байна. "Тиймээс ч сонин хэвлэлийн дизайны дүрст график элементийн илэрхийлэл, хэрэглээ, хэв байдлаараа бусдаас ялгаатай, өвөрмөц шийдэлтэй, бие даасан мэдээллийн орчин байх яриа өрнөж байна. Гэхдээ энэ нь уншигчдын сэтгэл зүй, үнэлэмж, хандлагаас үүдэж буй дизайны чиг хандлага юм"¹³.

Эдгээрээс дүгнэн хэлэхэд мэдээллийн технологийн боломж хэрэглээ нь сэтгүүлийн дизайныг нэгэн хэвийн цутгасан юм шиг адилхан, ижил хэв маягаас нь улам бүр татгалзуулж, уншигчид, зорилтот зах зээлийнхээ эрэлт, хэрэгцээг хангахуйц дизайн, хэв маягтай болгож байгаа юм. Энэ нь өнөөгийн Монголын сэтгүүлүүд дизайны хувьд улам чанаржиж, уншигчдын анхаарлыг татах, сонирхол төрүүлж өдөөх, өвөрмөц содон болж байгааг харуулж байна.

Ишлэл

- ¹ *Зулькафиль М.* 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 143 дахь тал.
- ² *Батжаргал Д.* 2013. Зуун жил. УБ., 49 дэх тал.
- ³ *Баасансүрэн Т.* 2009. 1921 оны ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил. УБ., Дэд дэвтэр, 183 дахь тал.
- ⁴ <http://baabar.niitlelch.mn/content/3794.shtml>
- ⁵ *Батжаргал Д.* 2013. Зуун жил. УБ., 49 дэх тал.
- ⁶ *Мөн тэнд,* 60 дахь тал.
- ⁷ *Баасансүрэн Т.* 2009. 1921 оны ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил. УБ., Дэд дэвтэр, 193 дахь тал.
- ⁸ *Болд-Эрдэнэ Б.* 2004. Сонины дизайн. УБ., 110 дахь тал.
- ⁹ *Эрдэнэцэцэг Т.* 2007. Сонины дизайны гарын авлага. УБ., 46 дахь тал.
- ¹¹ *Норовсүрэн Л.* 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Гутгаар боть. УБ., 215 дахь тал.
- ¹² *Дариймаа Н.* 2010. Сонины сэтгүүлч. УБ., 36 дахь тал.
- ¹³ *Болд-Эрдэнэ Б.* 2004. Сонины дизайн. УБ., 109 дэх тал.
- ¹⁴ 2005. Монголын сэтгүүл зүйн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд. 45 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Баасансүрэн Т.* 2009. 1921 оны ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил. УБ., Дэд дэвтэр.
2. *Батжаргал Д.* 2013. Зуун жил. УБ.
3. *Болд-Эрдэнэ Б.* 2004. Сонины дизайн. УБ.
4. *Дариймаа Н.* 2010. Сонины сэтгүүлч. УБ.
5. *Зулькафиль М.* 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
6. 2005. Монголын сэтгүүл зүйн өнөөгийн тулгамдсан асуудлууд. УБ.
7. *Норовсүрэн Л.* 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Гутгаар боть. УБ.
8. *Эрдэнэцэцэг Т.* 2007. Сонины дизайны гарын авлага. УБ.

Summary

As of 1987, a total of 36 magazines were issued throughout Mongolia and they were almost similar in the design and had no particular characteristics to distinguish from

one another. Their front page or cover was printed in color only to attract readers. However, the design, color, writing style and content of the magazines have dramatically changed since 1990 and it was the start of having the current forms.